


# Лекц

Профессор П лекц орох болгондоо анги дүүргэлтийг тооцолж гаргадаг. Мөн анги дүүргэлтээ тодорхой тооноос бага бол бүх оюутны 70 онооноос нэг нэгийг хасдаг.

Анги дүүргэлт гэдэг нь багана дүүргэлт болон мөр дүүргэлт гэсэн хоёр тооны аль багыг нь хэлнэ. Багана дүүргэлт гэдэг нь хамгийн олон оюутантай багана дахь оюутны тоо ба мөр дүүргэлт гэдэг нь хамгийн олон оюутантай мөрөнд сууж байгаа оюутны тоо юм.

Жишээ нь доорх зургийн зүүн талд 16 оюутан суусан байна (оюутан суусан сандал ширээг харлуулав).



Энэ байрлалд мөр дүүргэлт нь 5 (4-р мөр) ба багана дүүргэлт нь 3 (1, 3, 5, 6-р багана) байна. Иймд анги дүүргэлт нь 3 байна. Хэрэв оюутнууд баруун талын зурагт үзүүлсэн байдлаар суувал багана дүүргэлт 4 болно (5-р багана). Ингэснээр анги дүүргэлт нь ч 4 болно.

Профессор П-гийн оюутнууд хамгийн ихдээ анги дүүргэлтийг хэд болгож чадахаа мэдэхийг хүсч байгаа.

## Input

$n$ ,  $r$ ,  $c$  бүхэл тоонууд зайгаар тусгаарлагдан өгөгдөнө ( $0 < r, c < 101$ ,  $0 < n \leq r * c$ ). Тэдгээр нь харгалзан оюутны тоо, мөрийн тоо, баганын тоо болно.

## Output

Өгөгдсөн тооны оюутнууд өгөгдсөн ангийн анги дүүргэлтийг хамгийн ихдээ хэд болгож чадахыг гаргана.

## Example

**Input:**

3 5 10

**Output:**

2